



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/107/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.09.15 № 52
танай _____ -ны № _____ Т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Л.ГАНБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006000111


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>231,076,903.17</u>	<u>252,392,946.67</u>
34	УРЬДЧИЛГАА	1,868,151.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,868,151.00	00.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,868,151.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	229,208,752.17	252,392,946.67
351	Түүхий эд материал	100,975,622.13	121,898,059.13
35110	Тусгай зориулалттай материал	99,989,172.13	119,482,309.13
35130	Эм боох материал	986,450.00	2,415,750.00
354	Хангамжийн материал	107,562,942.04	107,633,037.54
35410	Бичиг хэргийн материал	21,797,578.00	28,303,704.00
35420	Аж ахуйн материал	5,295,200.00	2,984,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,606,900.00	3,245,500.00
35440	Түлш, шатах тослох материал	360.00	9,282,187.00
35450	Барилгын засварын материал	8,433,075.00	3,440,835.00
35460	Хүнсний материал	1,896,778.00	1,263,308.00
35470	Бусад хангамжийн материал	62,533,051.04	59,113,203.54
35600	Мал амьтад	20,670,188.00	22,861,850.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,534,990,244.87</u>	<u>2,486,676,124.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,534,990,244.87	2,486,676,124.40
392	Биет хөрөнгө	2,412,206,204.87	2,364,404,584.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,806,377,830.91	1,806,377,830.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,859,449.67	-73,642,171.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	370,349,823.04	302,820,835.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-241,718,307.62	-147,585,686.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	521,667,406.83	523,329,384.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,248,655.20	-134,036,560.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,924,539.00	45,427,210.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,854,539.16	-22,864,804.79
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	49,320,200.00	49,320,200.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,319,650.00	23,608,005.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,072,293.26	-8,349,657.58
393	Биет бус хөрөнгө	122,784,040.00	122,271,539.92
39301	Програм хангамж	2,452,327.00	1,025,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,427,327.00	-512,500.08
39303	Бусад биет бус хөрөнгө	121,759,040.00	121,759,040.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,766,067,148.04</u>	<u>2,739,069,071.07</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>120,906.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	120,906.00	00.00
413	Өглөг	120,906.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	120,906.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,765,946,242.04</u>	<u>2,739,069,071.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,765,946,242.04	2,739,069,071.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,110,542,957.28	1,110,542,957.28
51101	Өмч: - төрийн	1,110,542,957.28	1,110,542,957.28
512	Хуримтлагдсан үр дүн	1,054,439,641.89	1,029,058,643.18
51210	Өмнөх үеийн үр дүн	1,054,439,641.89	1,055,935,814.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-26,877,170.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	600,963,642.87	599,467,470.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,766,067,148.04</u>	<u>2,739,069,071.07</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,759,150,387.20</u>	<u>2,693,180,762.82</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>616,903,934.20</u>	<u>309,590,502.82</u>
120	Нийтлэг татварын бус орлого	616,903,934.20	299,590,502.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,603,750.00	232,749,359.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,603,750.00	14,650,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	218,099,359.00
120009	Бусад орлого	1,935,150.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	572.482.250.70	40,754,821.32
12001701	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө /Цагдаа/	572.482.250.70	22,095,021.32
12001702	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө /Бусад/	00.00	18,659,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	32.882.783.50	26,086,322.50
12001801	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал /Цагдаа/	32.882.783.50	25,386,322.05
12001802	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал /Бусад/	00.00	700,000.00
120009	Бусад орлого	1,935,150.00	00.00
122	Тусламжийн орлого	00.00	10,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,142,246,453.00</u>	<u>2,383,590,260.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,019,520,300.00	2,314,540,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,019,520,300.00	2,314,540,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	122,726,153.00	69,049,660.00

131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	2,342,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,340,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	115,386,153.00	66,707,160.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,220,796,946.64	2,720,057,933.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,220,796,946.64	2,720,057,933.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,210,933,196.64	2,710,696,097.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,682,562,128.00	1,921,550,543.00
210101	Үндсэн цалин	1,682,562,128.00	1,921,550,543.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,098,943.00	43,059,598.00
210201	Тэтгэврийн даатгал	3,930,402.00	3,937,023.00
210202	Тэтгэмжийн даатгал	462,395.00	426,788.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	369,921.00	367,476.00
210204	Ажилгүйдлийн даатгал	59,143.00	75,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,277,082.00	38,253,078.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,196,200.00	120,288,319.00
210301	Гэрэл, цахилгаан	7,876,364.00	11,233,525.00
210302	Түлш, халаалт	99,553,100.00	98,541,180.00
210303	Цэвэр, бохир ус	9,766,736.00	10,513,614.00
2104	Хангамж, бараа материалын зардал	117,888,525.00	148,702,277.20
210401	Бичиг хэрэг	10,286,252.00	12,944,855.20
210402	Тээвэр, шатахуун	97,395,173.00	120,246,364.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,313,000.00	8,956,378.00
210404	Ном, хэвлэл	00.00	53,060.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	385,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	534,100.00	3,778,700.00
210408	Бараа материал акталсны зардал	3,360,000.00	2,337,320.00
2105	Нормативт зардал	19,747,289.00	24,267,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,350.00	290,700.00
210502	Хоол, хүнс	19,689,939.00	23,100,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,000.00	876,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,144,452.00	53,888,310.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,762,700.00
210604	Урсгал засвар	16,144,452.00	51,125,610.00
2107	Томилолт, зочны зардал	63,064,440.00	23,985,100.00
210702	Дотоод албан томилолт	63,064,440.00	23,985,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,668,705.00	12,122,324.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	10,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	973,693.00	1,305,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	340,000.00	407,000.00
210807	Газрын төлбөр	232,100.00	232,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	122,912.00	178,224.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,562,514.64	362,832,576.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,775,170.00	6,258,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,730,172.80	3,664,847.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,057,171.84	352,909,688.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,863,750.00	9,361,836.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,260,000.00	5,260,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,260,000.00	4,760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,603,750.00	4,101,836.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,603,750.00	4,101,836.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	538,353,440.56	-26,877,170.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	538,353,440.56	-26,877,170.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,151,850,203.00	2,398,240,260.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,603,750.00	14,650,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,603,750.00	14,650,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,603,750.00	14,650,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,603,750.00	14,650,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,142,246,453.00	2,383,590,260.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,019,520,300.00	2,314,540,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,019,520,300.00	2,314,540,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	122,726,153.00	69,049,660.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	2,342,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,340,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	115,386,153.00	66,707,160.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,106,471,703.00	2,348,423,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,106,471,703.00	2,348,423,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,096,607,953.00	2,339,061,214.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,682,539,500.00	1,921,670,100.00
210101	Үндсэн цалин	1,083,133,900.00	1,079,519,700.00

210102	Нэмэгдэл	599,405,600.00	842,150,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,002,200.00	43,059,597.00
210201	Тэтгэврийн даатгал	3,930,402.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	331,195.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	369,921.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	59,143.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	33,311,539.00	43,059,597.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,196,200.00	120,288,319.00
210301	Гэрэл, цахилгаан	7,876,364.00	11,233,525.00
210302	Түлш, халаалт	99,553,100.00	98,541,180.00
210303	Цэвэр, бохир ус	9,766,736.00	10,513,614.00
2104	Хангамж, бараа материалын зардал	124,014,100.00	144,142,268.00
210401	Бичиг хэрэг	9,928,000.00	17,803,740.00
210402	Тээвэр, шатахуун	94,727,800.00	111,666,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,218,500.00	9,046,578.00
210404	Ном, хэвлэл	00.00	53,060.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	397,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,139,800.00	5,174,990.00
2105	Нормативт зардал	18,450,000.00	25,824,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,350.00	449,350.00
210502	Хоол, хүнс	17,617,650.00	22,565,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	2,809,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,431,000.00	42,647,580.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,998,700.00
210604	Урсгал засвар	33,431,000.00	38,648,880.00
2107	Томилолт, зочны зардал	63,064,440.00	23,985,100.00
210702	Дотоод албан томилолт	63,064,440.00	23,985,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,545,793.00	11,944,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	10,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	973,693.00	1,305,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	340,000.00	407,000.00
210807	Газрын төлбөр	232,100.00	232,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,364,720.00	5,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,364,720.00	3,050,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,450,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,863,750.00	9,361,836.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,260,000.00	5,260,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,260,000.00	4,760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,603,750.00	4,101,836.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,603,750.00	4,101,836.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	45,378,500.00	49,817,210.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	45,378,500.00	49,817,210.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,378,500.00	49,817,210.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,378,500.00	49,817,210.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,378,500.00	49,817,210.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-45,378,500.00	-49,817,210.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,542,957.28	601,250,437.20	515,799,407.00	00.00	2,227,592,801.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	286,794.33	00.00	286,794.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,110,542,957.28	601,250,437.20	516,086,201.33	00.00	2,227,879,595.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-286,794.33	00.00	00.00	-286,794.33
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	538,353,440.56	00.00	538,353,440.56
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,542,957.28	600,963,642.87	1,054,439,641.89	00.00	2,765,946,242.04
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,542,957.28	600,963,642.87	1,054,439,641.89	00.00	2,765,946,242.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,496,172.26	00.00	1,496,172.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,110,542,957.28	600,963,642.87	1,055,935,814.15	00.00	2,767,442,414.30
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,496,172.26	00.00	00.00	-1,496,172.26
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-26,877,170.97	00.00	-26,877,170.97
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,110,542,957.28	599,467,470.61	1,029,058,643.18	00.00	2,739,069,071.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,025,520,300	2,025,520,300	2,328,540,600	2,325,088,764
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,025,520,300	2,025,520,300	2,328,540,600	2,325,088,764
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,019,260,300	2,019,260,300	2,323,280,600	2,319,828,764
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,682,539,500	1,682,539,500	1,921,670,100	1,921,670,100
210101	Үндсэн цалин	1,083,133,900	1,083,133,900	1,079,519,700	1,079,519,700
210102	Нэмэгдэл	599,405,600	599,405,600	842,150,400	842,150,400
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,002,200	38,002,200	46,384,800	43,059,597
210201	Тэтгэврийн даатгал	198,500	3,930,402	00	00
210202	Тэтгэмжийн даатгал	23,400	331,195	00	00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,700	369,921	00	00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,700	59,143	00	00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,756,900	33,311,539	46,384,800	43,059,597
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,196,200	117,196,200	120,299,700	120,288,319
210301	Гэрэл, цахилгаан	7,876,300	7,876,364	11,233,600	11,233,525
210302	Түлш, халаалт	99,553,100	99,553,100	98,541,200	98,541,180
210303	Цэвэр, бохир ус	9,766,800	9,766,736	10,524,900	10,513,614
2104	Хангамж, бараа материалын зардал	110,035,300	110,035,300	142,972,900	142,888,398
210401	Бичиг хэрэг	9,928,000	9,928,000	14,968,000	14,967,370
210402	Тээвэр, шатахуун	91,588,800	91,588,800	110,123,800	110,123,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,218,500	6,218,500	9,063,500	9,046,578
210404	Ном, хэвлэл	00	00	120,000	53,060
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	00	00	397,600	397,600
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,300,000	2,300,000	8,300,000	8,299,990
2105	Нормативт зардал	15,530,000	15,530,000	21,125,000	21,124,150
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,400	132,350	450,000	449,350
210502	Хоол, хүнс	14,697,600	14,697,650	18,425,000	18,425,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000	700,000	2,250,000	2,249,800
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,020,000	26,020,000	36,020,000	36,011,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00	00	4,000,000	3,998,700
210604	Урсгал засвар	26,020,000	26,020,000	32,020,000	32,012,300
2107	Томилолт, зочны зардал	16,780,000	16,780,000	20,401,000	20,393,100

210702	Дотоод албан томилолт	16,780,000	16,780,000	20,401,000	20,393,100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,157,100	11,157,100	11,957,100	11,944,100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000	10,000,000	10,000,000	10,000,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	805,000	805,000	1,305,000	1,305,000
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000	120,000	420,000	407,000
210807	Газрын төлбөр	232,100	232,100	232,100	232,100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000	2,000,000	2,450,000	2,450,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000	2,000,000	2,450,000	2,450,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,260,000	6,260,000	5,260,000	5,260,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,260,000	6,260,000	5,260,000	5,260,000
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00	00	500,000	500,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,260,000	6,260,000	4,760,000	4,760,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,025,520,300	2,025,520,300	2,328,540,600	2,325,088,764
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,019,520,300	2,015,916,550	2,314,540,600	2,310,438,764
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,019,520,300	2,015,916,550	2,314,540,600	2,310,438,764
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000,000	9,603,750	14,000,000	14,650,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000	9,603,750	14,000,000	14,650,000
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	136	122	142	140
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	132	116	138	136
620003	Үйлчлэх ажилтан	03	05	03	04

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		69,049,660.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		69,049,660.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		69,049,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал		7,253,870.00
210401	Бичиг хэрэг		2,836,370.00
210402	Тээвэр, шатахуун		1,542,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,875,000.00
2105	Нормативт зардал		4,700,000.00
210502	Хоол, хүнс		4,140,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		560,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		50,453,790.00

210601	Багаж, техник, хэрэгсэл		43,817,210.00
210604	Урсгал засвар		6,636,580.00
2107	Томилолт, зочны зардал		3,592,000.00
210702	Дотоод албан томилолт		3,592,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3050000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,050,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	69049660.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		69,049,660.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,342,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		66,707,160.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга, хурандаа Л.Ганбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 08- наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Булган аймаг дахь Цагдаагийн газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31/01-131 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цагдаагийн газрын дэвшүүлсэн зорилт:

- Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлнэ

- Үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжинэ

Зорилтын хүрээнд 9 дэд ажлыг хэрэгжүүлж биелэлт 98 хувийн биелэлттэй гэж үнэлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 30-р тогтоол
- Засгийн газрын 2020 оны 02 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020 оны 106 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 78 дугаар тогтоол
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/47 дугаар тушаал
- ЦЕГ-ын 2020 оны А/08-р тушаал
- ЦЕГ-ын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/24-р тушаал
- Цагдаа, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/01-р тушаал

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цагдаагийн газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “54401.2 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 1273205.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 25464.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26998.1 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0

Авлага	0	0	0
Урьдчилгаа	1868.2	0	-1868.2
Бараа материал	229208.8	252392.9	23184.2
Үндсэн хөрөнгө	2534990.2	248676.1	-48314.1
Нийт хөрөнгө	2766067.1	2739069.1	-26998.1
Өр төлбөр	120.9	0	-120.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2765946.2	2739069.1	-26877.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2766067.1	2739069.1	-26998.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний болон эцсийн үлдэгдэл 0 мянган төгрөг байна. Урьдчилж гарсан зардлын эхний үлдэгдэл 1868.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 252392.9 мянган төгрөг болж 23184.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар өгсөн 10000.0 мянган төгрөгийн шатахуун болон 26086.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авснаас шалтгаалжээ. Бараа материалын тайлангийн тусгай зориулалт 20228.3, эм бэлдмэлд 240.0, аж ахуйн материалд 346.0, барилгын засварын материалд 1600.0, бусад хангамжийн материалд 10890.5 мянга буюу нийт 33304.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Няравын тайлангаар түлш халаалтын зардлаас авсан тос, тосол, товууд зэрэг шатахуунаас бусад материалыг сэлбэг хэрэгслийн тайланд орлого, зарлагаар бүртгэж тайлагнажээ.

Тайлант хугацааны эцсийн үлдэгдлээр 9282.2 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.9, эм боох материал 2.4 дахин их үлдэгдэлтэй буюу материалын нөөц үүсгэсэн байна. Энэ нь УИХ-ын гишүүн Ц.Анандбазар ковид-19 цар тахалтай холбоотой хандивласан 10000.0 мянган төгрөгийн шатахууны хандивтай холбоотой байна. Мал мах хяналт шалгалт болон ковид-19 цар тахалтай холбоотой пост гарч ажилласан 9-11 дүгээр сард хэргийн дуудлага өмнөх оны мөн үеэс 87-оос 66 буюу 24.1 хувиар буурчээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2486676.1 мянган төгрөг болж 48314.1 мянган төгрөгөөр буурсан нь 40243.1 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг шилжүүлж, 67602.5 мянган төгрөгийг өртөгтэй хөрөнгийг акталснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 49817.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 254778.4 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 40243.1 мянган төгрөг, акталсан 67602.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 1427.3 мянган төгрөгөөр буурсан нь программ хангамжийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2739069.1 мянган төгрөг болж 26877.2 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 65969.6 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 499260.9 мянган төгрөгөөр буюу 22.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс нэмэгдэл урамшил, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 1496.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь дахин үнэлэгдсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4347069.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4347069.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2109483.5 мянган төгрөгөөр бууруулж 2237586.3 мянган төгрөгөөр баталсан байна. Цалин хөлс нэмэгдэл урамшил 100073.1, хангамж бараа материалын зардал 56812.3, татаас 270588.5, хөрөнгийн зардал 1662701.4 мянган төгрөгөөр тус тус бууруулжээ. Тайлант онд төсөвт 2 удаагийн өөрчлөлт орж 2328540.6 мянган төгрөг болж 90954.3 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх цагдаа болон шүүгч болон гэрч, хохирогчийн 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2328540.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 2314540.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 14000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2310438.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 14650.0 мянган төгрөг нийт 2325088.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2325088.8 мянган төгрөгийг зарцуулж 4101.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2325088.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 3325.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь “цагдаа” хөтөлбөрийн арга хэмжээ 1883.0 мянган төгрөгөөр, “шүүгч болон гэрч, хохирогч” хөтөлбөрийн арга хэмжээ 1442.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2342.5, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 66707.2, нийт 69049.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 7253.9, норматив зардалд 4700.0, эд хогшил худалдан авахад 50453.8, томилолт зочны зардалд 3592.0, бараа үйлчилгээний бусад зардалд 3050.0 нийт 69049.7 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3590.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	3590.8	2	3590.8	1	0	0
Нийт дүн	3	3590.8	2	3590.8	1	0	0

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжид албан шаардлага хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 56186.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 41497.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 14688.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ажилтан, албан хаагчийн цалингийн шатлал, хавсран, шинээр томилогдсон тушаалаар цалинг тооцон олгохдоо хоногийн зөрүүнээс үүдэн илүү, дутуу олгосон 240.0 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнаас суутгаж залруулсан
2. Эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайлангийн бичиг хэргийн материалын эхний үлдэгдэл нярвын бичиг хэргийн материалын эхний үлдэгдэл 5648.2 мянган төгрөгөөр дутуу, шатахууны тайланд 89.5 мянган төгрөгийн орлого, 25.8 мянган төгрөгийн зарлагыг дутуу тайлагнасныг залруулсан.
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 9331.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсныг баримтын бүрдлийг хангаж залруулсан.
4. Тайлант хугацааны нэг дүгээр сарын 6000.0 мянган төгрөгийн орлого, 6563.1 мянган төгрөгийн зарлага бүхий шатахууны баримтыг үдэж архивын нэгж болгоогүйг архивын нэгж үүсгэн залруулсан.
5. Тайлант хугацаанд 19600.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны журнал бичилтийг алдаатай бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Зөвлөмжийн биелэлт хангагдаагүйд албан шаардлага хүргүүлээ Үүнд:

1. Тус газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/40 тоот тушаалаар тооллогын комиссыг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилсон боловч тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй байдаг ч хэрэгжүүлж ажиллаагүй, 2020 оны А/68 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого хийсэн баримтыг архивын нэгж үүсгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", НББ-ийн тухай хуулийн 11.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 14688.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Цагдаагийн газрын даргын 03 дугаар сарын 12-ны Б/37, Б/39, 05 дугаар сарын 21-ний өдрийн Б/64, 06 дугаар сарын 10-ны Б/86 тоот тус тус тушаалаар давхардсан тоогоор 109 албан хаагчдад 11603.6 мянган төгрөгийг 2-5 сарын ажлыг дүгнэж цалингийн нэмэгдэл олгосон, мөн сахилгын шийтгэлтэй албан хаагчдад тус нэмэгдэлд хамрагдсан байна.

1.2.Эрсдэл: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох, дотоод хяналт сулрах

1.3.Өгсөн зөвлөмж Үр дүнгийн урамшууллыг сар бүр олгодог зөрчлийг таслан зогсоож ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: НӨАТТ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ", 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.5 дахь "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төлбөрийн баримтгүй худалдан авалт хийсэн.

2.2. Эрсдэл: Хууль, журам мөрдөгдөхгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинжтэй 4 тооны 7635.1 мянган төгрөгийн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнах

3.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангиллын залруулга хийж, УСНББОУС-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Сумдад ажиллаж буй албан хаагчдын хэрэглэсэн нийт 29235.9 мянган төгрөгийн шатахууныг холбогдох албан тушаалтнаар хянуулж баталгаажуулсны дараа шилжүүлгийг хийдэг бөгөөд нярвын тайланд тусгахдаа шилжүүлэг хийсэн үеэр орлого авдаг нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Маягт заавар батлах" журмын 3-т "Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх заавар" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

4.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг бүрэн хэрэгжүүлж

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн, хэрэгжүүлэн ажиллаж байна.


Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Булган аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



ДАНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР

ТАЙЛАН БИЧСЭН:
ГР0А0048 3190269



А.СУВДАА